# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

| | | |
|---|---|---|
| 2023 оны 12 дугаар сарын 15 -ны өдөр | Дугаар А/441, А/192 | Улаанбаатар хот |

Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хууль (шинэчилсэн найруулга)-ийн 43 дугаар зүйлийн 43.5 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэг, Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт"-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тушаалыг мөрдөж ажиллахыг Эрүүл мэндийн магадлалын төв, салбар, орон нутгийн зөвлөл, эмнэлгийн байгууллагын Эмнэлэг хяналтын комисст тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн магадлалын зөвлөл, Эмнэлэг хяналтын комисс, холбогдох эмч, мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах, даатгуулагч, хүнд мэдээлэл өгч, сурталчилж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар /А.Өнөржаргал/, Нийгмийн даатгалын ерөнхий газар /Л.Мөнхзул/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлд тус тус даалгасугай.

4.Өвчний жагсаалтаас хасагдсан эсхүл өөрчлөгдсөн өвчний заалтаар урьд нь хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрийн хүчин төгөлдөр хугацааг дуусах хүртэл хугацаанд хэвээр үргэлжлүүлсүгэй.

5.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эмнэлэг тусламж, үйлчилгээний газар /А.Өнөржаргал/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/-т тус тус даалгасугай.

6.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/758, А/197 дугаар хамтарсан тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

7.Энэхүү тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЧИНЗОРИГ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

Х.БУЛГАНТУЯА

*Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 15 өдрийн А/441, А/192 дугаар хамтарсан тушаалын хавсралт*

# ДААТГУУЛАГЧ, ХҮНИЙ ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДАЛТЫН ХУВЬ, ХУГАЦАА, ШАЛТГААНЫГ МАГАДЛАХ, ХӨДӨЛМӨР ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХЭД БАРИМТЛАХ ӨВЧНИЙ ЖАГСААЛТ

| № | Өвчний нэр | Үе шат | Өвчний код | Хувь хэмжээ | Хугацаа | Хөдөлмөрийн нөхцөл солих, |
|---|---|---|---|---|---|---|
| | | А.Ердийн өвчин болон ахуйн осол | | | | |
| | | **1.ХАЛДВАРТ ӨВЧИН** | | | | |
| | | **Амьсгалын эрхтний сүрьеэ** | | | | |
| 1.1 | Амьсгалын эрхтний сүрьеэгийн хүнд, хүндэвтэр хэлбэр зүрх судасны дутагдлын II, III үе | А. Амьсгал болон бусад эрхтний сүрьеэгийн шинэ тохиолдлын хүнд, хүндэвтэр хэлбэр, амьсгалын дутагдал II үе | А15 | 70 | 2 жил хүртэлх | |
| | | Б. Амьсгал, бусад эрхтний сүрьеэгийн давтан тохиолдлын хүнд, хүндэвтэр хэлбэр, амьсгалын дутагдал III үе | | 80 | 2 жил | |
| 1.2 | Уушги болон бусад эрхтэнд сүрьеэ өвчний улмаас мэс засал хийлгэсэн | А. Тухайн эрхтний үйл ажиллагааны дутагдалгүй | | 70 | 2 хүртэлх жил | |
| | | Б. Тухайн эрхтний үйл ажиллагааны дутагдалтай | | 80 | 2 жил | |
| 1.3 | Сорвит хөндийт сүрьетэй, сэдрэлийн үе, архаг хордлого, хоёр уушги хамарсан зүрх судасны дутагдлын II, III үе | | | 80 | 2 жил | |
| | | **Уушгины бус эрхтний сүрьеэ** | | | | |
| 1.4 | Сүрьеэгийн мэнэн идэвхтэй үедээ ба өвчилсний дараах үед тэнцвэр, хараа, сонсгол, хөдөлгөөний эрхтний үлдэц өөрчлөлтийн аль нэг илэрсэн бол | Сэдрэлийн ба намжмал үе | А17 | 80 | 2 жил | |
| 1.5 | Өвдөг, түнх, тохой, мөрний үений сүрьеэгийн хүндрэлийн улмаас үений хөдөлгөөн бүр мөсөн буюу 2/3 нь хязгаарлагдсан бол | Сэдрэлийн ба намжмал үе | А18 | 70 | 2 жил | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Нурууны сүрьеэ (хүзүү, сээр, бүсэлхий, ууцны нугалам)-ын улмаас нурууны үений хөдөлгөөн 2/3-оос дээш хязгаарлагдаж хөдөлгөөнгүй болсон, аль нэг мөчинд саажилт үүссэн бол | Сэдрэлийн ба намжмал үе | A18 | 70 | 2 жил | |
| 1.6 | Сүрьеэгийн улмаас эрхтэн тогтолцооны талаас дахин сэргэхгүй өөрчлөлтөнд орсон (амьсгал, зүрх судасны архаг дутагдалтай, яс үе мөчний сүрьеэ, менингит) | | | 80 | 2 жил | |
| | **Эмэнд тэсвэртэй сүрьеэ** | | | | | |
| 1.7 | а/Амьсгалын ба бусад эрхтний эмэнд тэсвэртэй сүрьеэ (ЭТС)-ийн улмаас эмчлэгдэж байгаа болон эмчилгээний дараах үе | Сэдрэлийн ба намжмал үе | A15-A19 | 80 | 2 жил | |
| 1.8 | б/Амьсгалын болон бусад эрхтний маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн (МОЭТС) бүх тохиолдол | Сэдрэлийн ба намжмал үе | A15-A19 | 90 | хугацаагүй | |
| 1.9 | ДОХ, ХДХВ-ийн халдварын 1-4 дүгээр шат | а/ХДХВ-ийн халдварын эмнэлзүйн I-II үе шат(Ретровирусийн эсрэг эмчилгээнд 12 сар ба түүнээс дээш хугацаанд >95% тууштай хамрагдсан) | B20<br>B21<br>B22<br>B23<br>B24 | 60 | 2 жил | |
| | | б/ ХДХВ-ийн халдварын эмнэлзүйн III үе шат (Ретровирусийн эсрэг эмчилгээнд 6 сар ба түүнээс дээш хугацаанд >95% тууштай хамрагдсан) | | 70 | 2 жил | |
| | | в/ ХДХВ-ийн халдварын эмнэлзүйн IV үе шат- ДОХ (Ретровирусийн эсрэг эмчилгээ эхэлсэн байх) | | 80 | 2 жил | |
| 1.10 | Бруцеллёз | а/Ээнэгшил хагас алдсан өөртөө үйлчлэх чадвартай (остеоартит, остеоартоз, спондилит) спондилёз, коксартроз) | A23 | 50 | 1 жил | |
| | | б/Ээнэгшил бүрэн алдсан, өөртөө үйлчлэх чадвартай (фиброз, анкилоз, үений хэлбэр, бүтэц алдагдаж эргэшгүй өөрчлөлттэй) бруцеллёзын ийлдсийн шинжилгээ сөрөгжсөн буюу үлдэц хэлбэртэй | | 70 | 2 жил | |
| | | в/Ээнэгшил бүрэн алдсан, өөртөө үйлчлэх чадваргүй | | 80 | Хугацаагүй | |
| 1.11 | Хачигт энцафалит | Эрхтэн тогтолцооны саажилт, үлдэц хэлбэр | B88, B94 | 80 | Хугацаагүй | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **2.СЭТГЭЦ, ЗАН ҮЙЛИЙН ЭМГЭГ** | | | | | | |
| **Сэтгэцийн органик ба шинж тэмдгийн эмгэг** | | | | | | |
| 2.1 | Альцгеймер өвчний тэнэгрэл, судасны гаралтай өвчний тэнэгрэл, пикийн, хантингтон өвчний тэнэгрэл, халдварын шалтгаант, тархины гэмтлийн шалтгаант, эпилепсийн үеийн тэнэгрэл | а/Хэсэгчилсэн тэнэгрэлд орж бусдын асрамж шаардлагатай бол | F00 F01 F02 F02.2 F02.8 | 80 | 2 жил | |
| | | б/Бүрэн тэнэгрэлд орж бусдын байнгын асрамж шаардлагатай бол | | 90 | Хугацаагүй | |
| **Тархины гэмтэл ба үйлийн хямрал, бие махбодийн өвчний шалтгаант сэтгэцийн бусад эмгэг** | | | | | | |
| 2.2 | Органик галлюциноз, органик кататоник, органик дэмийрэл, органик сэтгэл цочирдлын эмгэг | Хий үзэгдэл, кататони, дэмийрэл, сэтгэл хөдлөлийн шинжүүд илэрч, дахилттай бол | F06.0 F06.1 F06.2 F06.3 | 70 | 2 жил | |
| **Тархины өвчин, гэмтэл, үйл ажиллагааны хямралын шалтгаант бие хүний зан үйлийн эмгэг** | | | | | | |
| 2.3 | Бие хүний органик эмгэг | а/Зан төрхийн тод өөрчлөлттэй, танин мэдэхүй, сэтгэхүй, хэл ярианы өөрчлөлттэй хавсарсан бол | F07.0 | 60 | 1 жил | |
| | | б/Зан төрхийн болон танин мэдэхүй, сэтгэхүй, хэл ярианы гүнзгий өөрчлөлттэй бол | | 70 | 2 жил | |
| 2.4 | Тархины өвчин, гэмтэл, үйл ажиллагааны шалтгаант бие хүний ба зан төрхийн бусад органик эмгэг | а/Зан төрхийн мэдэгдэхүйц өөрчлөлттэй, эмэнд дарагддаггүй уналт таталттай бол | F07.8 | 60 | 1 жил | |
| | | б/Зан төрхийн гүнзгий өөрчлөлттэй, эмэнд дарагддаггүй уналт таталттай бол | | 70 | 2 жил | |
| | | в/Зан төрхийн гүнзгий өөрчлөлттэй, ухамсарт ухаан бүрийтэн балартал, солиорол бүхий уналт таталттай бол | | 80 | 2 жил | |
| **Сэтгэц идэвхт эм, бодисын шалтгаант сэтгэц, зан үйлийн эмгэг** | | | | | | |
| 2.5 | Архи, опиойдын, каннабиноидын, тайвшруулах нойрсуулах бодисын, кокайны, сэргээгч эм бодисын, хий үзэгдэл үүсгэгч эм бодисын, дэгдэмхий уусгагч бодисын, олон төрлийн сэтгэц идэвхт бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэцийн болон зан үйлийн эмгэг | Архи, опиойдын, каннабиноидын, тайвшруулах нойрсуулах бодисын, кокайны, сэргээгч эм бодисын, Хий үзэгдэл үүсгэгч эм бодисын, дэгдэмхий уусгагч бодисын, олон төрлийн сэтгэц идэвхт бодисын шалтгаант солиорол (паранойд) хоорондоо богино хугацааны давтамжтай эсвэл тэнэгрэл илэрсэн бол | F10 F11 F12 F13 F14 F15 F16 F18 F19 | 70 | 2 жил | |
| **Шизофрени, шизофренийн хэв шинжит ба дэмийрэх эмгэг** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.6 | Шизофренийн хий үзэгдэл дэмийрлийн, хүүхдэрхэх, кататоник, үл ялгагдах, шизофренийн дараах сэтгэл гутрал, үлдэц шизофрени, энгийн хэлбэрүүд, бусад шизофрени | а/Солиорол (хий үзэгдэл, дэмийрэл, паранойд, Кандинский-Клеромбо, гебефрени, кататони, сэтгэл гутралын)–ын шинжүүд тод, эмчилгээний үр дүнд засарсан хэдий ч орчиндоо дасан зохицох чадвар буурсан бол | F20.0<br>F20.1<br>F20.2<br>F20.3<br>F20.4<br>F20.5<br>F20.6<br>F20.8 | 60 | 1 жил | |
| | | б/Солиорол (хий үзэгдэл, дэмийрэл, паранойд, Кандинский-Клеромбо, гебефрени, кататони, сэтгэл гутралын) – ын шинжүүд тогтвортой тод илэрч, өвчин дахих бүрт негатив шинжүүд ихэсч байгаа боловч засрал сайжралд ордог бол | | 70 | 2 жил | |
| | | в/Солиорол (хий үзэгдэл, дэмийрэл, паранойд, Кандинский-Клеромбо, гебефрени, кататони, сэтгэл гутрал, парафрени)-ын шинжүүд бүдэг буюу үлдэц хэлбэрээр тогтвортой негатив шинжүүдийн суурин дээр илэрч, засрал сайжралд ордоггүй бол | | 80 | 2 жил | |
| | | г/Өвчний төгсгөлийн үе буюу шизофренийн негатив, позитив шинжийн аль аль нь арилахгүйгээр илэрч, бие даан амьдрах чадваргүй, бусдын хараа хяналт, асрамж шаардлагатай бол | | 100 | Хугацаагүй | |
| 2.7 | Шизофренийн хэв шинжит эмгэг | а/Этгээд төрх, ер бусын итгэл үнэмшил, хачин бодол санаа, сенестопати, дереализаци, деперсонализаци, дисморфофоби, үл ялих зовлонт үзэгдэл шинжүүд тод, солиорлын шинжүүд бүдэг илэрч, орчиндоо дасан зохицох чадвар буурсан бол | F21 | 60 | 1 жил | |
| | | б/Этгээд төрх, ер бусын итгэл үнэмшил, хачин бодол санаа, сенестопати, дереализаци, деперсонализаци, дисморфофоби, үл ялих зовлонт үзэгдэл шинжүүд тод, солиорлын шинжүүд тод илэрч байгаа боловч засрал сайжралд ордог бол | | 70 | 2 жил | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | в/Этгээд төрх, ер бусын итгэл үнэмшил, хачин бодол санаа, сенестопати, дереализаци, деперсонализаци, дисморфофоби, үл ялих зовлонт үзэгдэл шинжүүд тод, солиорлын шинжүүд бүдэг илэрч байгаа боловч засрал сайжралд ордоггүй бол | | 80 | 2 жил | |
| | | г/Өвчний төгсгөлийн үе буюу үлдэц бүхий шинжтэй, бие даан амьдрах чадваргүй, бусдын хараа хяналт, асрамж шаардлагатай бол | | 90 | Хугацаагүй | |
| 2.8 | Байнга дэмийрэх эмгэг | а/Солиорол (системчлэгдсэн дэмийрэл)-ын шинжүүд тод илэрч, орчиндоо дасан зохицох чадвар буурсан бол | F22 | 60 | 1 жил | |
| | | б/Солиорол (системчлэгдсэн дэмийрэл)-ын тод илэрч байгаа боловч засрал сайжралд ордог бол | | 70 | 2 жил | |
| | | в/Солиорол (системчлэгдсэн дэмийрэл)-ын тод илэрч байгаа боловч засрал сайжралд ордоггүй бол | | 80 | 2 жил | |
| | | г/Өвчний төгсгөлийн үе буюу солиорол (системчлэгдсэн дэмийрэл) тод илэрч бие даан амьдрах чадваргүй, бусдын хараа хяналт, асрамж шаардлагатай бол | | 90 | Хугацаагүй | |
| **Шизоаффектив эмгэг** | | | | | | |
| 2.9 | Шизоаффектив эмгэгийн сэтгэл хөөрөх, гутрах, холимог хэлбэр | а/Шизоаффектив эмгэгийн солиорол (сэтгэл цочирдол, хий үзэгдэл, дэмийрэл, кататоник) бүхий сэтгэл хөөрөх, гутрах, холимог шинжүүд дахин давтагдан илэрч буй бол | F25.0<br>F25.1<br>F25.2 | 60 | 1 жил | |
| | | б/Шизоаффектив эмгэгийн солиорол (сэтгэл цочирдол, хий үзэгдэл, дэмийрэл, кататоник) бүхий сэтгэл хөөрөх, гутрах, холимог шинжүүд ээлжлэн тасралтгүй илэрч буй бол | | 70 | 2 жил | |
| **Сэтгэл цочирдлын хоёр туйлт эмгэг** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.10 | Солиорлын шинж тэмдэгтэй сэтгэл хөөрөл, гутрал, холимог шинж бүхий хоёр туйлт сэтгэл цочирдох эмгэг, сэтгэл гутрах дахилтат үечилсэн эмгэг | а/Сэтгэл цочирдлын хоёр туйлт (сэтгэл хөөрөл, сэтгэл гутрал,холимог шинж) сэтгэл гутралын дахилтат эмгэг 6 сараас дээш хугацаанд дахиж буй бол | F31.2<br>F31.5<br>F31.6<br>F33.1<br>F33.2<br>F33.3 | 60 | 1 жил | |
| | | б/Сэтгэл цочирдлын хоёр туйлт (сэтгэл хөөрөл, сэтгэл гутрал, холимог шинж) сэтгэл гутралын дахилтат эмгэг 6 сараас доош хугацаанд дахиж, олон жилээр үргэлжилж буй бол | | 70 | 2 жил | |
| **Стресстэй холбоотой неврозын болон биеийн хэлбэрийн эмгэгүүд** | | | | | | |
| 2.11 | Айдаст сэтгэл түгших, үл ялих зовлонт үзэгдлийн, дасан зохицохуйн, диссоциатив, биеийн хэлбэрийн, мэдрэл сульдах эмгэгүүд | Эмчилгээний үр дүнд сайжрал авдаг боловч мэргэжлийн ажлаа хийх боломжгүй болсон бол | F40<br>F42<br>F43<br>F44<br>F45<br>F48 | - | - | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| 2.12 | Бие хүний паранойд, шизойд, диссоциатив, сэтгэлийн хөдөлгөөний тогтворгүй, истерийн, ананкаст,хараат, холимог ба бусад эмгэг | Бие хүний эмгэгүүд ээнэгшил алдагдалт 4-6 сар үргэлжилсэн тохиолдолд | F60.0<br>F60.1<br>F60.2<br>F60.3<br>F60.4<br>F60.5<br>F60.7<br>F61.0 | 50 | 1 жил | |
| **Оюуны хомсдолын эмгэг** | | | | | | |
| 2.13 | Оюуны хөнгөн хомсдол | Оюуны хөнгөн хомсдол (IQ-50-69)/Насанд хүрсэн хүний сэтгэл зүйн нас 9-12 насны хүүхдийнхтэй ижил түвшний хөгжилтэй/ | F70 | 60 | 2 жил | |
| 2.14 | Оюуны хүндэвтэр хомсдол | Оюуны хүндэвтэр хомсдол (IQ 35-49) /Насанд хүрсэн хүний сэтгэл зүйн нас 6-9 насны хүүхдийнхтэй ижил түвшний хөгжилтэй/ | F71 | 70 | 3 жил | |
| 2.15 | Оюуны хүнд хомсдол | Оюуны хүнд хомсдол (IQ 20-34) /Насанд хүрсэн хүний сэтгэл зүйн нас 3-6 насны хүүхдийнхтэй ижил түвшний хөгжилтэй/ | F72 | 80 | Хугацаагүй | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.16 | Оюуны гүнзгий хомсдол | Оюуны гүнзгий хомсдол (IQ 20 хүртэл) /Насанд хүрсэн хүний сэтгэл зүйн нас 3 наснаас бага хүүхдийнхтэй ижил түвшний хөгжилтэй/, байнгын гардан асаргаа шаардлагатай бол | F73 | 90 | Хугацаагүй | |
| 2.17 | Аутизмын хүрээний эмгэгүүд | Нийгмийн харилцаанд оролцох чадвар сул, бусдын хараа хяналт, асрамж шаардлагатай бол | F84.0<br>F84.2<br>F84.5 | 80 | 3 жил | |
| | | **3. ДОТРЫН ӨВЧНҮҮД** | | | | |
| 3.1 | Зүрхний архаг дутагдал (атеросклероз. зүрхний шигдээс, кардиомиопати, артерийн гипертензи, хэрэх, зүрхний төрөлхийн ба бусад олдмол эмгэг хамаарна) | а/ЗАД-ын "С" шат, диастолын дутагдал, ачаалал даах чадвар буурсан, зүрхний хэт авиан шинжилгээгээр зүрхний бүтцийн өөрчлөлттэй EF=41-49%, A/E<0.9 ба натри хөөгч пептидийн сорилоор NT-pro BNP >450 пг/мл байх | I50 | 60 | 2 жил | |
| | | б/ЗАД-ын "D" шат, ЦЭД IV систолын дутагдал ачаалал даах чадвар буурсан, зүрхний хэт авиан шинжилгээгээр зүрхний бүтцийн өөрчлөлттэй EF≤40% ба натри хөөгч пептидийн сорилоор NT-pro BNP >1800 пг/мл байх | I50 | 80 | 2 жил | |
| 3.2 | Артерийн гипертензи | а/Бөөрний архаг дутагдлын II үе шат тархины цусан хангамжийн архаг дутагдал | I10 | 60 | 1 жил | |
| | | б/Бөөрний архаг дутагдлын III үе шат. нүдний угт торлог бүрхэвчийн хаван, ховхролт үүссэн, тархинд цус харваж, саажилт үлдсэн | I10 | 70 | 2 жил | |
| | | в/Хоруу явцтай эмэнд тэсвэртэй артерийн гипертензи | I10 | 60 | 1 жил | |
| 3.3 | Зүрхний ишеми өвчин, Цээжний бах | а/Цээжний тогтвортой бах үйл ажиллагааны III зэрэг: зүрхний ачаалалтай сорилоор үйл ажиллагааны зэрэг нотлогдсон байх, титэм судасны зураг авах шинжилгээгээр титэм судас 50-75%-ийн нарийсалтай байх | I20 | 60 | 1 жил | |
| | | б/Цээжний тогтвортой бах үйл ажиллагааны IV зэрэг: тайван үеийн ЗЦБ-д ишемийн шинж илэрсэн байх, титэм судасны зураг авах шинжилгээгээр олон титэм судас > 75%-ийн нарийсалтай байх, эмийн эмчилгээ үр дүнгүй байх | I20 | 70 | 2 жил | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | в/Титэм судсан дотуурх эмчилгээний дараа цээжний бах дахих: титэм судасны стент тавиулсаны дараа ЗЦБ-т ишемийн өөрчлөлт арилахгүй байх эсвэл шинээр илрэх, титэм судасны зураг авах шинжилгээгээр титэм судасны нарийсал дахин илрэх | I20 | 70 | 1 жил | |
| 3.4 | Зүрхний шигдээс | а/Хүндрэлгүй, дунд зэргийн эрсдэлтэй: ST сегмент өргөгдсөн шигдээсийн онош ЗЦБ, ЗХАШ-р нотлогдох, ST сегмент өргөгдөөгүй шигдээс, шигдээсийн онош ЗЦБ ба тропонины сорилоор нотлогдох | I21-I22 | 55 | 1 хүртэлх жил | |
| | | б/Хүндрэл илэрсэн эрсдэлийн зэрэг өндөр байх: шигдээсийн хүндрэл маш өндөр эрсдэл нотлогдсон байх | I21-I22 | 70 | 2 жил | |
| 3.5 | Хүнд хэлбэрийн түр зуурын муужралт (синкопи) өгдөг хэм алдагдлууд | а/Пароксизмал тахикарди, тосгуур ховдлын хориг III зэрэг, синусын зангилааны сулралын хам шинж, эмийн эмчилгээнд үр дүнгүй тосгуурын жирвэгнээ 12 сарын дотор багадаа 3 удаа муужирч унасан | I47<br>I48<br>I44<br>I49<br>I45 | 60 | 1 жил | |
| | | б/Электростимулятор тавигдсаны дараах үе | I47 I48<br>I44 I49<br>I45-Z45<br>Z95 | 50 | 1 хүртэлх жил | |
| 3.6 | Халдварт эндокардит | Тархи, зүрх бөөр дэлүүнд хүндрэл өгсөн | I33 | 60 | 1 жил | |
| 3.7 | Зүрхний төрөлхийн ба олдмол гажиг | а/Ачааллын хөхрөлттэй: баруунаас зүүн тийш цусны урсгал илэрсэн, ачаалал ≤ 5 МЕТ | I05-I09<br>Q20-Q28 | 50 | 1 жил | |
| | | б/Насанд хүрэгсдийн төрөлхийн гажиг засах мэс заслын эмчилгээний дараа (PASP<45 мм.муб) | Q20-Q28<br>I05-I09<br>T82 | 50 | 1 хүртэлх жил | |
| | | в/Хиймэл хавхлага суулгах мэс заслын эмчилгээний дараа | T82 | 50 | 1 жил | |
| 3.8 | Уушгины артерийн анхдагч, хоёрдогч даралт ихсэлт | а/PASP=45-59мм МУБ | I27 | 70 | 2 жил | |
| | | б/PASP≥ 60 мм МУБ | I27 | 80 | 2 жил | |
| 3.9 | Хоёр хавтаст хавхлагын унжилт | Хүнд зэргийн хавхлага солих мэс заслын эмчилгээ хийлгэх заалттай тохиолдолд | I34 | 50 | 1 жил | |
| 3.10 | Гол судас. том салааны цүлхэн | а/Хууралтгүй цүлхэн /5 см дээш/ | I71 I72 | 60 | 1 жил | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | б/Хууралттай цүлхэн | I71 I72 | 70 | 2 жил | |
| 3.11 | Захын судасны эмгэг | а/Гүний судасны эмгэг нь босох, суух, өргөх, түлхэх зэрэг ажил хөдөлмөртэй холбоотой үйл ажиллагааны алдагдал үүсгэх | I83 | - | - | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | б/Хөлийн гүний венийн судасны эмгэг багадаа 3 сараас доошгүй хугацаагаар үргэлжилсэн, хөлд байнгын хаван, тэжээлийн өөрчлөлттэй | I83 | 50 | 1 жил | |
| | | в/Мөчдийн судасны хагалгааны дараах үе /Гүний артер венийн судас/ | I83 | 50 | 1 хүртэлх жил | |
| | | г/Хөл эсвэл гарын хурууны үзүүр үхжиж эхлэх үе | I83 | 70 | 2 жил | |
| | | д/Энэ өвчнөөр хөл эсвэл гар аль нэг түвшинд тайруулсан | I83 | 80 | Хугацаагүй | |
| ***Ревматологийн өвчнүүд*** | | | | | | |
| 3.12 | Тогтолцооны улаан чонон яр | а/Өндөр идэвхжилтэй, түгмэлээр олон эрхтэн тогтолцоог гэмтээсэн боловч аль нэг эрхтний үйл ажиллагааны дутагдал илрээгүй | M32 | 60 | 2 жил | |
| | | б/Өндөр идэвхжилтэй, түгмэлээр олон эрхтэн тогтолцоог гэмтээж, аль нэгэн эрхтний үйл ажиллагааны дутагдал илэрсэн байх | M32 | 70 | 3 жил | |
| 3.13 | Ревматоид артрит | а/Өндөр идэвхжилтэй, олон үений үйл ажиллагаа алдагдсан, хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал II-III зэрэг | M05 M06 | 60 | 1 жил | |
| | | б/Өндөр идэвхжилтэй, хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал IV зэрэг эсвэл түгмэлээр эрхтэн тогтолцоог гэмтээсэн ба аль нэг эрхтний үйл ажиллагааны дутагдал илэрсэн | M05 M06 | 80 | 2 жил | |
| 3.14 | Васкулит | а/Өндөр идэвхжилтэй, түгмэлээр олон эрхтэн тогтолцоог гэмтээсэн боловч аль нэг эрхтний үйл ажиллагааны дутагдал илрээгүй | L95 | 60 | 1 жил | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | б/Өндөр идэвхжилтэй, түгмэлээр олон эрхтэн тогтолцоог гэмтээж, аль нэгэн эрхтний үйл ажиллагааны дутагдал илэрсэн байх | L95 | 70 | 2 жил | |
| 3.15 | Тогтолцооны хатуурал | а/Өндөр идэвхжилтэй, түгмэлээр олон эрхтэн тогтолцоог гэмтээсэн боловч аль нэг эрхтний үйл ажиллагааны дутагдал илрээгүй | M34 | 60 | 1 жил | |
| | | б/Өндөр идэвхжилтэй, түгмэлээр олон эрхтэн тогтолцоог гэмтээж, аль нэгэн эрхтний үйл ажиллагааны дутагдал илэрсэн байх | M34 | 70 | 2 жил | |
| 3.16 | Дерматомиозит, полимиозит | а/Өндөр идэвхжилтэй, түгмэлээр олон эрхтэн тогтолцоог гэмтээсэн боловч аль нэг эрхтний үйл ажиллагааны дутагдал илрээгүй | M33 | 60 | 1 жил | |
| | | б/Өндөр идэвхжилтэй, түгмэлээр олон эрхтэн тогтолцоог гэмтээж, аль нэгэн эрхтний үйл ажиллагааны дутагдал илэрсэн байх | M33 | 70 | Хугацаагүй | |
| 3.17 | Ясны төрөлхийн болон олдмол эмгэгүүд (несовершенный остеогенез, гиперостоз, ясны тэжээл алдагдлын үжлүүд) | а/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал II-III зэрэг | Q78, M90.3-M90.5 | 60 | 1 жил | |
| | | б/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал IV зэрэг | Q78, M90.3-M90.5 | 70 | Хугацаагүй | |
| 3.18 | Нурууны эмгэгүүд (дорсопати, нуруу гулсах, спондилопати барьцалдаат спондилитын хүндэвтэр хэлбэр) | а/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал II-III зэрэг | M45-M49 | 60 | 1 жил | |
| | | б/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал IV зэрэг эсвэл дотор эрхтний үйл ажиллагааны алдагдал | M45-M49 | 70 | Хугацаагүй | |
| | | в/ Энэ өвчний үед гар, хөл тайрах мэс засал хийгдсэн, хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал III-IV зэрэг | M86 M87 M89 | 80 | Хугацаагүй | |
| 3.19 | Ясны архаг идээт үрэвсэл (остеомиелит, ясны үжил, пажетийн өвчин, яс ясны чөмөгний үрэвсэл, гэмтлээс хатуурал, хөндий үүссэн) | а/Мэс заслын эмчилгээ хийгдсэн боловч, биеийн ерөнхий хордлого нэмэгдсэн буюу ясанд эмгэг өөрчлөлт үргэлжилсэн | M86.9 | 70 | 1 хүртэлх жил | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | б/Энэ өвчний улмаас хөл тайрах мэс засал хийгдсэн, хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал III-IV зэрэг | | 80 | хугацаагүй | |
| 3.20 | Рейно хам шинж | а/Гарын хуруунд трофик өөрчлөлт гарч, цусгүйдэл болж, байнгын өвдөлттэй | I73 | 50 | 1 жил | |
| | | б/Өвчин даамжирч гарын хуруунуудад их хэмжээний үхжил үүсч тайрах мэс засал хийлгэсэн | I73 | 70 | Хугацаагүй | |
| 3.21 | Ясны бүтцийн эмгэгүүд (хүнд хэлбэрийн ясны сийрэгжилт, яс зөөлрөлт, остеит пэджетийн, реклингхуазен, бехтеровын өвчин) | а/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал II-III зэрэг | M81 | 60 | 1 жил | |
| | | б/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал IV зэрэг | M81 M83 M90.6 M88 | 70 | Хугацаагүй | |
| 3.22 | Мөгөөрсний эмгэгүүд (Легга-Кальве-Пертесийн өвчин, остеохондроз, хондродисплазия, остеодисплазия, остеохондропатия) | а/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал II-III зэрэг | M81 M83 M90.6 M88 | 60 | 1 жил | |
| | | б/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал IV зэрэг | M91 M42 | 70 | Хугацаагүй | |
| 3.23 | Булчин, шөрмөс, зөөлөн эдийн өвчин | а/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал II-III зэрэг | M60 M61 M62 M63 M68 M70-M79 M76 M79.9 | 60 | 1 жил | |
| | | б/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал IV зэрэг | | 70 | Хугацаагүй | |
| 3.24 | Архаг тофустай, өвчний идэвхжилийн өндөр зэрэгтэй, хүндрэлтэй тулай. | а/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал II-III | | 60 | 1 жил | |
| | | б/Хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдал III-IV, бусад эрхтэн тогтолцоонд хүндрэлтэй | | 70 | 2 жил | |
| ***Амьсгалын эрхтний эмгэгүүд*** | | | | | | |
| ***Уушгины амьсгалах талбайг хязгаарласан эмгэгүүд*** | | | | | | |
| 3.25 | Амьсгалын эрхтний гаж хөгжил, дутуу хөгжил, нуруу, цээжний хэнхэрцгийн деформаци, фибриторакс | а/Амьсгалын дутагдал I, цусны эргэлтийн дутагдал "В" үе шат, Спирографи: VC 56-69% MLV 55-58%, FEV1/VC 74-55%. ЭхоКГ: зүрхний баруун ховдлын агших чадвар дунд зэрэг буурч уушгины гемодинамик алдагдах | J96.1 J94.1 M40 | 60 | 2 жил | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | б/Амьсгалын дутагдал II, зүрхний архаг дутагдлын "C" үе шат, Спирографи:VC 50-55%, MLV 51- 54%, FEV1/VC 54-40%. ЭхоКГ: зүрхний баруун ховдлын агших чадвар буурч уушгины гемодинамик алдагдах | J96.1<br>J94.1 | 70 | 2 жил | |
| | | в/Амьсгалын дутагдал III, зүрхний архаг дутагдлын "D" үе шат Спирографи: VC≤50%, MLV50%, FEV1/VC< 40%, ЭхоКГ: баруун ховдлын агших чадвар буурч уушгины гемодинамик алдагдах | J96.1<br>J94.1 | 90-100 | Хугацаагүй | |
| 3.26 | Уушигны завсрын эдийн эмгэгүүдийн улмаас үүссэн фиброз, хөндий | а/Уушгины фиброз: зөгийн үүрийн шинж, амьсгалын архаг дутагдлын II-III зэрэг, зүрхний архаг дутагдлын "C" үе шат | J84.1 | 80 | 2 жил | |
| | | б/Уушгины фиброз: зөгийн үүрийн шинж, амьсгалын архаг дутагдлын III зэрэг, зүрхний архаг дутагдлын "D" үе шат | J84.1 | 90 | Хугацаагүй | |
| | | ***Агаар дамжуулах зам ба цулцангийн эмгэгүүд*** | | | | |
| 3.27 | Гуурсан хоолой тэлэгдэх өвчин | а/Эмийн эмчилгээнд үр дүнгүй, мэс засал хийлгэх шаардлагатай, амьсгалын дутагдлын II зэрэг, зүрхний дутагдлын "B", "C" үе шат | J47 | 60 | 1 жил | |
| | | б/ГХТӨ 2 талыг хамарсан, мэс засал хийлгэсэн буюу давтан хийлгэх шаардлагатай, амьсгалын дутагдлын III зэрэг, зүрхний архаг дутагдлын "C" үе шат илрэх | J47 | 70 | 2 жил | |
| | | в/Амьсгалын дутагдлын III зэрэг, уушгины цус алдалтын улмаас цус багадалтын III зэрэг, бөөрний амилоидозын улмаас бөөрний дутагдалын III зэрэг, туралын III зэрэг, зүрхний архаг дутагдлын "C", "D" үе шатын аль нэг илрэх | J47 | 80 | Хугацаагүй | |
| 3.28 | Гуурсан хоолойн багтраа | а/Дунд зэрэг, амьсгалын дутагдлын I-II зэрэг, хөдөлгөөний хязгаарлалт I зэрэг | J45-J46 | 50 | 1 жил | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | б/Хүнд зэрэг, амьсгалын дутагдлын II-III зэрэг, зүрхний дутагдлын "В", "С" үе шат, гормон эмчилгээний гаж нөлөөний улмаас дотоод шүүрлийн тогтолцооны үйл ажиллагаа алдагдах (чихрийн шижин, бөөрний дээд булчирхайн дутагдал) | J45-J46 | 70 | 2 жил | |
| | | в/Маш хүнд зэрэг, эмчилгээний үр дүн муу, амьсгалын дутагдлын III зэрэг, зүрхний архаг дутагдлын "D" үе шат, бусад эрхтний талаас органик өөрчлөлт илэрсэн, өөртөө үйлчлэх чадвар алдагдах | J45-J46 | 80 | 2 жил | |
| 3.29 | Уушигны архаг бөглөрөлт өвчин | а/Амьсгалын дутагдал I зэрэг, зүрхний архаг дутагдлын "В" үе шат, Спирографи: FEV1 50-79%. FEV1/FVC< 0.7, ЭхоКГ: зүрхний баруун ховдлын агших чадвар дунд зэрэг буурч уушгины гемодинамик алдагдах | J44 | - | - | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | б/Амьсгалын дутагдал II зэрэг, цусны эргэлтийн дутагдал "С" үе шат Спирографи: FEV1 31-49%. FEV1/FVC< 0.7 ЭхоКГ: зүрхний баруун ховдлын агших чадвар буурч уушгины гемодинамик алдагдах | J44 | 70 | 2 жил | |
| | | в/Амьсгалын дутагдлын III зэрэг, зүрхний архаг дутагдлын "D" үе шат, өөртөө үйлчлэх чадвар алдалт III зэрэг, Спирографи: FEV1≤30%. FEV1/FVC< 0.7. ЭхоКГ: баруун ховдлын агших чадвар буурч уушгины гемодинамик алдагдах | J44 | 80 | 2 жил | |
| 3.30 | Уушигны артерийн бүлэнт бөглөрөл | | | 70 | 1 жил | |
| | ***Хоол боловсруулах эрхтний эмгэг*** | | | | | |
| 3.31 | Улаан хоолойн сорвижилт нарийсал, ахалази ээнэгшил алдагдсан үе | | K22 | 50 | 2 жил | |
| 3.32 | Нарийн бүдүүн гэдэсний эмгэг | а/Кроны өвчний хүнд хэлбэр | K50 | 70 | 2 жил | |
| | | б/Бүдүүн гэдэсний шархлаат үрэвслийн хүнд хэлбэр | K51 | 70 | 2 жил | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | в/Нарийн гэдэсний архаг эмгэг, тэжээлийн хүнд дуталтай: глютены энтеропати, эозинофилт энтеропати, туяа эмчилгээний дараах энтеропати | K90.9 K90 K52 | 70 | 2 жил | |
| 3.33 | Нойр булчирхайн архаг үрэвслийн дахилтат болон өвдөлттэй хэлбэр | | K86 | 50 | 1 хүртэлх жил | |
| 3.34 | Элэгний эмгэг | а/Элэгний эмгэг Гепатитийн В, Делта вирусын шалтгаант архаг үрэвслийн үед Д вирусийн эсрэг өвөрмөц эмчилгээ (пег-интерферон, булевиртид, лонафарниб) хийх хугацаанд | B18 | 80 | 2 жил | |
| | | б/Элэгний цирроз Чайльд-Пьюгийн ангиллаар "А" зэрэг | K74 | 60 | 1 жил | |
| | | в/Элэгний цирроз Чайльд-Пьюгийн ангиллаар "В"зэрэг | K74 | 70 | 2 жил | |
| | | г/Элэгний цирроз Чайльд-Пьюгийн ангиллаар "С"зэрэг | K74 | 80 | Хугацаагүй | |
| | | д/Порфирины эмгэг, хожуу үеийн арьс, элэгний хэлбэр | E80.1 E80.2 | 50 | 1 жил | |
| | | е/Аутоиммуный элэгний эмгэг (аутоиммун гепатит, билиар цирроз гэх мэт бусад эрхтэн тогтолцооны өөрчлөлт илэрсэн байх) | K75.4 | 80 | 2 жил | |
| | | ***Бөөрний эмгэгүүд*** | | | | |
| 3.35 | Бөөрний түүдгэнцэрийн өвчин | а/Архаг гломерулонефрит (цустай шээх хэлбэр), бөөрний биопсийн заалтад нийцсэн үед бөөрний эдийн шинжилгээг хийж онош баталгаажсан байх | N02 N03 | 50 | 1 жил | |
| | | б/Архаг анхдагч болон хоёрдогч гломерулонефрит (нефроз, даралт ихсэх, холимог хэлбэр) | N04 N05 | 70 | 2 жил | |
| 3.36 | Бөөрний судасны эмгэг | Бөөрний судасны төрөлхийн болон олдмол гаж хөгжил, судас дарагдлаас болсон артерийн даралт ихдэлт | I15.0 | 50 | 2 хүртэлх жил | |
| 3.37 | Төрөлхийн болон эрхтэн тогтолцооны өвчин эмгэгийн үед илрэх нефропати | Хоёрдогч нефропати (нефроз, даралт ихсэх, сувганцрын дутагдлын хам шинжтэй хэлбэр) | N07 N08 | 70 | 2 жил | |
| 3.38 | Бөөрний дутагдал | а/Цочмог дутагдлын дараах байдал | N17 | 50 | 1 хүртэлх жил | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | б/Бөөрний архаг дутагдал IIIб үе /түүдгэнцрийн шүүлтийн хурд 45-30 мл/мин/ | N18.3 | 70 | 2 жил | |
| | | в/Бөөрний архаг дутагдал IV, V үе /түүдгэнцрийн шүүлтийн хурд 30 мл/мин/-ээс буурсан үед | N18.4<br>N18.5 | 80 | Хугацаагүй | |
| ***Дотоод шүүрлийн өвчнүүд*** | | | | | | |
| 3.39 | Чихрийн шижин хэв шинж 1 архаг эзэгшил алдагдалтай эсвэл өсөлтийн хоцрогдолтой | | E10 | 70 | 2 жил | |
| 3.40 | Чихрийн шижингийн хожуу үеийн хүндрэлтэй | а/Жижиг судасны хүндрэлтэй (ретинопати, нефропати, невропатийн аль нэг шинж илэрсэн бол) | E11.2<br>E11.4<br>E11.3 | 50 | 1 жил | |
| | | б/Том судасны хүндрэлтэй (зүрхний шигдээс, тархины цус харвалт, захын артерийн судасны бөглөрөлттэй) | E11.5<br>E11.6<br>E11.7 | 70 | 2 жил | |
| | | в/Том ба жижиг судасны хүндрэлийн улмаас (хараа бүрэн алдсан, гемодиализад ордог эсвэл бөөр шилжүүлэн суулгах мэс засал хийлгэсэн, шаркогийн хөл үүссэн) эрхтэн тогтолцооны архаг дутагдалтай | E11.7 | 80 | Хугацаагүй | |
| 3.41 | Тархмал хордлогот бахуу | а/Бамбайн хордлогын дунд, хүнд зэрэг, эзэгшлийн бус үе | E05 | - | - | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | | б/Бамбайн хордлогын хүнд хэлбэр: нүдний хүнд хэлбэрийн офтальмопати ба зүрхний тогтвортой хэм алдагдал | E05 | 70 | 2 жил | |
| | | в/Бамбайн хордлогын хүнд хэлбэр: цусны эргэлтийн дутагдал | E05 | 80 | Хугацаагүй | |
| | | г/Мэс заслын дараах хүндрэлтэй (кальцийн дутагдал гипопаратиреоз, N.recurrens саа) | E20 | 65 | 1-2 хүртэлх жил | |
| 3.42 | Гипотиреоз | а/Хүнд хэлбэр буюу микседемийн хаван, перикардит | E03 | 50 | 1-2 хүртэлх жил | |
| | | б/Төрөлхийн хэлбэр оюуны болон биеийн хөгжлийн илэрхий хоцрогдолтой | E03 | 70 | Хугацаагүй | |
| 3.43 | Чихрийн бус шижингийн хүнд хэлбэр | | | 70 | 2 жил | |
| 3.44 | | а/Биеийн өндөр 131-140 см бол | E23 | 60 | Хугацаагүй | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Өнчин тархины ба бусад шалтгаантай өсөлтийн дааврын дутагдал | б/Биеийн өндөр 130 см буюу түүнээс доош бол | E23 | 70 | Хугацаагүй | |
| 3.45 | Адреногениталь хам шинж | а/Энгийн эрших хэлбэр | E25 | 60 | 1-2 хүртэлх жил | |
| | | б/Давс хаях хэлбэр | E25 | 70 | 2 жил | |
| 3.46 | Бөөрний дээд булчирхайн архаг дутагдлын хүнд хэлбэр | | E27 | 65 | 1-2 хүртэлх жил | |
| 3.47 | Иценко-Кушингийн өвчин ба хам шинжийн хүнд хэлбэр | | E24 | 70 | 2 жил | |
| 3.48 | Пангипопитуитаризм, гиперпаратиреодизм, феохромоцитома, гиперaлдостеронизм, пролактинома зэрэг ховор тохиолддог дотоод шүүрлийн эмгэгийн хүнд хэлбэр | | E22 | 70 | 2 жил | |
| ***Цусны өвчин:*** | | | | | | |
| 3.49 | Аплазийн цус багадалт, миелодисплазийн хам шинж | | D60 D61 | 80 | 2 жил | |
| 3.50 | Цус задралын цус багадалт /Шөнийн шээсэнд гемоглобин гарах эмгэг, удамшлын микросфероцитоз, аутоиммун цус задрал, таласеммия, гемоглобинопатия/ | | D59 | 70 | 2 жил | |
| 3.51 | Гистоцитоз (Гошегийн өвчин, макрофагийн эмгэгүүд) | | D76.1 | 70 | 2 жил | |
| 3.52 | Цус бүлэгнэлтийн эмгэг /Виллебрандын өвчин, гемофили А ба В/ | | D66 D67 D68 | 80 | Хугацаагүй | |
| 3.53 | Дархлалын шалтгаант ялтас цөөрөх эмгэг (иммун тромбоцитопени) | | D69.3 | 70 | 2 жил | |
| 3.54 | Цочмог лейкеми | | C91 | 100 | 2 жил | |
| 3.55 | Миелопролифератив эмгэгүүд: Архаг миелолейкеми, миелофиброз, жинхэнэ тромбоцитеми, жинхэнэ полицитеми (эритреми) | | C92 D75 | 80 | 2 жил | |
| 3.56 | Лимфопролифератив эмгэгүүд: (Ходжкины бус лимфом, ходжкины лимфом, лимфогрануломатоз, архаг лимфолейкеми) | | C81 | 80 | 2 жил | |
| 3.57 | Парапротейнемийн эмгэг (Түгмэл миелома, плазмоцитома, вальденстромийн макроглобулинемия) | | C88 C90 | 80 | 2 жил | |
| 3.58 | Төрөлхийн тромбоцитопатия | | D69.3 | 70 | 2 жил | |
| 3.59 | Ясны чөмөг, цусны үүдэл эс шилжүүлэн суулгасны дараах үе | | | 90 | 2 жил | |
| **5.НҮДНИЙ ӨВЧИН** | | | | | | |
| 5.1 | Нэг нүдний хараа хэвийн (тохирсон шилээр 0,3 ба үүнээс сайн хараатай), нөгөө нүд нь сохор (0,05-аас дор хараатай) | | H15-H48 H52 H53-H54 | 50 | 3 жил | |
| 5.2 | Зохих эмчилгээ хийлгэсний дараа тохирсон шилээр хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд 0,1- 0,3 хараатай (ДЭМБ-ын тодорхойлолтоор дунд зэргийн сул хараат) | | | 70 | 3 жил | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5.3 | а. Зохих эмчилгээ хийлгэсний дараа тохирсон шилээр хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд 0,05-0,09 хараатай (ДЭМБ-ын тодорхойлолтоор хүнд зэргийн сул хараат) | | 80 | 3 жил | |
| | б.Харааны талбай хоёр нүдэнд 20° хүртэл нарийссан (төвийн хараа нь хэвийн байсан ч) эсвэл "Глауком өвчний оношилгоо, эмчилгээ"-ний стандартын дагуу хоёр нүдний дунд зэргийн харааны талбайн алдагдалтай | | | | |
| 5.4 | а. Зохих эмчилгээ хийлгэсний дараа тохирсон шилээр хоёр нүдний илүү сайн харж байгаа нүд 0,05-аас дор хараатай (ДЭМБ-ын тодорхойлолтоор сохор) | | 100 | Хугацаагүй | |
| | б. Харааны талбай хоёр нүдэнд 10° хүртэл нарийссан (төвийн хараа нь хэвийн байсан ч) эсвэл "Глауком өвчний оношилгоо, эмчилгээ"-ний стандартын дагуу хоёр нүдний хүнд зэргийн харааны талбайн алдагдалтай | | | | |
| 5.5 | Төрөлхийн өнгөт харааны гажигтай (хэвийн өнгөт хараа шаардагдах бүх төрлийн мэргэжил, тухайлбал жолооч, нисэгч, лаборант г.м) | | - | - | Хөдөлмөрийн нөхцөл солих |
| | **6.ЧИХ, ХАМАР ХООЛОЙН ӨВЧИН** | | | | |
| 6.1 | а/Хоёр чихний сонсгол: Хэнгэргэн хальс нөхөх, дунд чихний нөхөн сэргээх мэс заслын дараа дуу дамжуулах хэлбэрээр сонсголын түвшин /41-45 дБ/, | H70 H71 H72 H90.0-H90.6 | 60 | 1 жил | |
| | б/Хоёр чихний сонсгол: мэдрэл-мэдрэхүйн ба холимог хэлбэрт /41-55 дБ/ бууралттай, чих шуугилттай | | 60 | 1 жил | |
| 6.2 | Нэг чихний сонсгол: Дунд чихний нөхөн сэргээх мэс заслын дараа дуу дамжуулах болон холимог хэлбэрээр сонсголын түвшин 51-ээс дээш дБ, чих шуугилт болон тэнцвэр алдалт хавсарсан, нөгөө чих нь мэдрэл-мэдрэхүйн /40-ээс дээш дБ/ сонсгол бууралттай, чих шуугих хам шинж хавсарсан | H71 H90.A1 H90.A2 H90.A3 | 50 | 2 жил | |
| 6.3 | Дунд чихний гаралтай гавал-тархины идээт үрэвсэл, буглааны хүндрэлийн мэс заслын дараах байдалтай сонсгол муу, үг таних чадвар муу, чих шуугих, тэнцвэр алдагдах, уналт таталт, ой ухаан муудах | H70 G06 H90.A3 | 50 | 2 жил | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6.4 | Дахилтат дунд чихний нөхөн сэргээх мэс заслын дараах байдал: Нэг талын чих сонсгол мэдрэл-мэдрэхүйн /61дБ-ээс дээш/ бууралттай, нөгөө чих нь холимог болон мэдрэл-мэдрэхүйн /51-ээс дээш дБ/ сонсгол бууралттай, сонсгол муу, үг таних чадвар муу, чих шуугих, тэнцвэр алдагдах, хэлярианд өөрчлөлт орсон | H71 H70 H90.A2 H90.A3 | 60 | 2 жил | |
| 6.5 | Нэг талын чих сонсгол мэдрэл-мэдрэхүйн /81дБ-ээс дээш/ бууралттай, нөгөө чих нь холимог болон мэдрэл-мэдрэхүйн /41-ээс дээш дБ/ сонсгол бууралттай, үг таних чадвар муу, чих шуугих | H66 H70.8 H70.9 H71 H74 H90.A2 H90.A3 | 60 | 2 жил | |
| 6.6 | Хоёр чихний сонсгол: Мэдрэл-мэдрэхүйн болон холимог хэлбэрийн хүнд зэргийн /71-90 дБ/ бууралттай, үг таних чадвар муу, чих шуугих (Зүрх судасны эмгэгтэй болон бусад эрхтэн системийн хүнд эмгэгийн улмаас мэс заслын эсрэг заалттай) | H70.8 H71 H74 H90.3 H90.6 | 80 | 3 жил | |
| 6.7 | Олдмол дүлий үед (2 чихний сонсгол 80 дБ-ээс дээш бууралттай бол) хэлтэй бол | H71 H74 H95 H90.3 H90.6 | 80 | Хугацаагүй | |
| 6.8 | Төрөлхийн таг дүлий (хэлгүй бол) | H91.3 | 100 | Хугацаагүй | |
| 6.9 | Нэг чихний гадна, дунд чихний төрөлхийн гажигтай бөгөөд нөгөө чих нь дамжуулах болон мэдрэл-мэдрэхүйн холимог хэлбэрийн 41 дБ-ээс дээш бууралттай, үг таних чадвар муу | Q16.1 Q17 H90.0 H90.6 | 60 | 2 жил | |
| 6.10 | Вестибуляр гаралтай, эмийн эмчилгээнд сайжирдаггүй, олон дахилттай толгой эргэлт,, тэнцвэрийн өөрчлөлт (огилт бөөжилт, чих шуугих, сонсгол бууралт хавсарсан), Меньер, сонсгол муу,чих шуугих,тэнцвэр алдагдах, хөдөлгөөний хязгаарлагдмал байдал | H81.0 | 60 | 1 жил | |
| 6.11 | Тэнцвэрийн мэдрэлийн хавдар, 2 талын вестибуляр гаралтай хавдрын бус, эмийн эмчилгээнд сайжирдаггүй, олон дахилттай толгой эргэлт, тэнцвэрийн өөрчлөлт (огилт бөөжилт, чих шуугих, сонсгол бууралт хавсарсан) хөдөлгөөний хязгаарлагдмал байдал, хэвтрийн дэглэм | D33.3 H81.23 H93.3 | 70 | 2 жил | |
